

БНМАУ, ЗСБНХУ ба БНХАУ-ын хооронд төмөр замын шууд харилцаа байгуулах тухай хэлэлцээр

Москва. 1952 оны 9 дүгээр сарын 15.

Нэг талаас БНМАУ-ын Засгийн Газар ба ЗСБНХУ-ын Засгийн Газар хоорондоо тохиролцсоны үндсэн дээр, нөгөө талаас БНХАУ-ын Ардын Төв Засгийн Газар тус орнуудын хоорондын эдийн засаг, соёлын холбоог өргөтгөх ба төмөр замын шууд харилцааг тогтоох зорилгоор хэлэлцэн тохирсон нь:

Нэгдүгээр зүйл

Дээр дурдсан зорилгоор БНМАУ-ын нутаг дээр Улаанбаараас Замын-Үүдийн орчим байгаа монгол-хятадын хил хүртэл БНХАУ-ын нутаг дээр Цзинин (Пиндицюан)-аас Эрляний орчим байгаа хятад-монголын хил хүртэл төмөр зам байгуулах тухай БНМАУ-ын Засгийн Газар ба Зөвлөлт Засагт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн Газар нь БНХАУ-ын Засгийн Газартай тохиролцов.

Хоёрдугаар зүйл

Хэлэлцэгч Этгээдүүд нь дээр дурдсан төмөр замуудыг байгуулах явдлыг байгуулах хоёр чиглэлээс нэгэн зэрэг гүйцэтгэхээр хэлэлцэн тохирсон бөгөөд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын нутаг дээр байгуулах төмөр замыг БНМАУ ба СССР-ээс Монгол-зөвлөлтийн хэлэлцээр ёсоор барьж гүйцэтгэх ба харин хятадын нутаг дээрхийг

ОЛОН УЛС СУДЛАЛ

БНХАУ-аас барьж гүйцэтгэхээр хэлэлцэн тохиров.

Гуравдугаар зүйл

Хэлэлцэгч Этгээдүүд нь энэ Хэлэлцээрийн нэгдүгээр зүйлд дурдсан төмөр замуудыг 1524 мм өргөн, дан замтай бөгөөд хоногт 12 хос галт тэргийг нэвтрүүлэх чадалтайгаар байгуулаад дараа уул замуудыг Хэлэлцэгч Этгээдүүдийн тохиролцсоноор хоногт 24 хос галт тэрэг нэвтрүүлэх чадалтай болгохоор хэлэлцэн тохиров.

Дөрөвдүгээр зүйл

Төмөр замын шууд харилцааг бүх шугамаар нь 1955 оны эцэст нээсэн байхын тул уул төмөр замуудыг 1953 онд байгуулж эхлэхээр Хэлэлцэгч Этгээдүүд хэлэлцэн тохиров. Эдгээр замын шинжилгээ ба төлөвлөгөөний ажлыг 1952 онд эхлэнэ.

Тавдугаар зүйл

Энэ хэлэлцээр нь гарын үсэг зурсан даруй хүчин төгөлдөр болно. Энэ Хэлэлцээрийг Москва хотноо 1952 оны 9 сарын 15-ны өдөр, монгол, орос, хятад хэл дээр тус бүр гурван хувь үйлдсэн бөгөөд гурван эх нь цөм адил хүчинтэй болно.

Зөвлөлийн Засагт Социалист
Бүгд Найрамдах Холбоот
Улсын Засгийн газрын эрх
олгосоноор
А.Вышинский

Бүгд Найрамдах
Монгол Ард Улсын
Засгийн газрын эрх
олгосоноор
Ю.Цэдэнбал

Бүгд Найрамдах
Хятад Ард Улсын
Засгийн газрын эрх
олгосоноор
Чжоу Энх Лай

Монгол-Зөвлөлтийн харилцаа. 1921-1974.

Баримт материал. Хоёрдугаар боть.

1941-1974. Нэгдүгээр хэсэг.

УБ., 1981. т..224-226